



**СҮХБААТАР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22000
Утас, факс: 70510051



БАТЛАВ.
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
М.ИДЭРБАТ

2024.01.17 № 01

2024 онд хийгдэх санхүүгийн
хяналт шалгалт, дотоод аудитын
нэгдсэн удирдамж

Нэг. Нийтлэг үндэслэл

Төсвийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.3-д "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна", Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар түүний байгууллагын болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ оршдог нийт байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харьяалал, өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр хянан шалгах", 8.2.3-д "сум дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна", Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.2 дахь заалтыг үндэслэн баталсугай.

Хоёр. Хяналт шалгалтын зорилго

Монгол улсын "Төсвийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Шилэн дансны тухай", "Захиргааны ерөнхий" хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын хүрээнд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, эрсдэлийн удирдлагаар хангахад оршино.

Гурав. Хамрах хүрээ, бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны хяналт шалгалт, дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хавсралт 1-д дурдсан 19 сэдвийн хүрээнд 121 объектын үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудитыг тус албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, дотоод аудиторуд 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хооронд багтаан хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Шалгалтад хамрагдах асуудлууд

4.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, хамтын гэрээ, үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль, тогтоол, заавар журмууд, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилт;

4.2 Төсвийн хөрөнгийн захиран зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалтын байдал;

4.3 Харилцах, кассаас зарцуулсан мөнгөний баримтын бүрдэл, хууль эрх зүйн үндэслэл;

4.4 Төсвийн орлого төвлөрүүлэлтийн байдал;

4.5 Улс, орон нутгийн төсөв, сангууд, дотоод гадаадын хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, хандив, зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн зориулалт, зарцуулалт, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал, ашиглалт, зээлийн эргэн төлөлт, үр өгөөжийн байдал;

4.6 Шалгагдсан байгууллагуудын ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, олголтын байдал, баримтын бүрдэлт, тооцоо бодолт;

4.7 Өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт;

4.8 Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх;

4.9 Иргэн, аж ахуй нэгж байгууллагатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдал;

4.10 Өмнө хийгдсэн шалгалтууд төлбөр, зөрчил, түүний барагдуулалт;

4.11 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт;

4.12 Засгийн газрын 311 дүгээр тогтоолын хэрэгжилт, дотоод хяналт шалгалтын ажилтан томилон ажиллуулсан эсэх

4.13 Аймаг, сумдын ТӨХК, ТӨҮГ, ОНӨААТҮГ-ын үр ашгийн байдал.

4.14 Байгууллагын засаглал, Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналтын үйл ажиллагаа төлөвшилийг үнэлж, дүгнэж, зөвлөмж өгөх

- 4.15 Үйл ажиллагааны үр дүнгийн байдалд дүгнэлт хийж зөвлөмж өгөх
- 4.16 Өмнөх дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийг үнэлэх
- 4.17 Байгууллагын үйл ажиллагаа, эрсдэл ба дотоод хяналтын тогтолцооны талаар мэдээлэл олж авахын тулд асуулга авах, холбогдох баримт бичигтэй танилцах
- 4.18 Байгууллагын үйл ажиллагааны урсгалыг зураглах, эрсдэл ба хяналтыг тодорхойлж, үнэлэх
- 4.19 Удирдлагаас хэрэгжүүлдэг гол дотоод хяналтуудыг сорил хийн шалгаж үр дүнг нэгтгэх
- 4.20 Дотоод хяналтын сорилын үр дүнд илэрсэн асуудлуудын үндсэн шалтгааны шинжилгээ хийж, удирдлагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- 4.21 Дотоод аудитын тайлан бэлтгэж, даргын зөвлөлд танилцуулан батлуулах, аудитын үр дүнг эргэн хянах

Тав. Үүрэг хариуцлага

5.1 Хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага


- 5.1.1 Шаардлагатай тайлан мэдээ, санхүүгийн баримт материалыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх;
- 5.1.2 Шалгалтын явцад холбогдох программ хангамжид нэвтэрч шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах;
- 5.1.3 Шалгалтын танилцуулгын төсөлтэй танилцаж санал, тайлбар өгөх;
- 5.1.4 Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах;
- 5.1.5 Дотоод аудитын хорооноос гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх.

5.2 Хяналт шалгалт хийх ажлын хэсэг

- 5.2.1 Хяналт шалгалт, дотоод аудитыг явуулахдаа удирдамжийн хүрээнд ажиллах
- 5.2.2 Шалгалтын ажлын явцад хамрагдаж буй байгууллага, газрын талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах
- 5.2.3 Шалгалтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу чанартай, бие даасан байдалтай гүйцэтгэх

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР



Т.ЦЭРЭГБАЯР

Аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 17-н өдрийн 01 тоот Нэгдсэн удирдамжийн хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

1220100005
ТУ32325 9051449

Тус онд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг 19-н сэдвийн хүрээнд 121 объектыг хамруулан хийнэ.

№	Хяналт шалгалт дотоод аудитад хамрагдах асуудал	Хамрагдах объектын тоо	Шалгалтын хэлбэр		
			СХШ	ДА	Хамтарсан
1	Сумдын ОНХСан	13		1	
2	Аймаг, сумдын ТӨХК, ТӨҮГ, ОНӨААТҮГ-ын үр ашгийн байдал	21			1
3	Сумдын ИТХ	13	1		
4	Сумдын ЗДТГ	13			1
5	Аймаг сумдын Хүүхдийн цэцэрлэг	24			1
6	Сумдын Соёлын төвүүд	12	1		
7	Хоршоо хөгжүүлэх сан	13			1
8	Жаахан шарга ХЖТеатр үйл ажиллагаа	1		1	
9	Шилэн дансны хуулийн хэрэгжилт	1		1	
10	Бичигт дэх Гаалийн газар	1	1		
11	Татварын хэлтэс	1			1
12	Аймгийн ЗДТГ	1	1		
13	Талын зам ТӨХК	1	1		
14	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ийн Сүхбаатар салбар	1	1		
15	Баруун-Урт нисэх буудал ТӨҮГ	1	1		
16	Аймгийн улс, орон нутгийн хөрөнгө оруулалт	1		1	
17	Уламжлалтын нэгдсэн эмнэлэг	1	1		
18	Сүхбаатар сум Боловсрол, эрүүл мэндийн сан	1			1
19	Дөрвөлж ОНӨААТҮГ	1			1
Нийт		121	8	4	7

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА